



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



MONGOLIAN NATIONAL
MINING ASSOCIATION



Монголын олборлох
үйлдвэрлэлийн ил тод
байдлын санаачилга



Сэлэнгэ аймгийн Засаг
даргын Тамгын газар




Дархан-Уул аймгийн Засаг
даргын Тамгын газар



Говьсүмбэр аймгийн Засаг
даргын Тамгын газар

ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН НЭГДСЭН ЧУУЛГА, УУЛЗАЛТ- ЗӨВЛӨМЖ

Дархан хот, 2023 оны 07-р сарын 03-05-ны өдрүүд



1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ:

1.1. Төр бодлогоор зарим бүс нутгийг байгалийн унаган төрхөөр нь хадгалж үлдээх, тусгай зөвшөөрөл олгох хяналтыг илүү сайжруулах;

2. ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ:

2.1. Уул уурхайн компаниудаас орон нутагт төлж байгаа татвар, төлбөр, хандив тусламжийг төсвийн цоорхой, дутагдлыг нөхөх, цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга төдий бус, тухайн аймаг, ялангуяа сум, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, шинэ бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж улс орон, бүс нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсвийн төлөвлөгөөг харгалзан үзэж уялдуулан зохицуулах;

3. БАЙГАЛЬ, ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ-Д:

3.1. Хууль зөрчиж тусгай зөвшөөрөл олгосон төрийн албан хаагчид хатуу хариуцлага тооцох мөн тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан аж ахуйн нэгжийн хийсэн нөхөн сэргээлтийг иргэний нийгмийн оролцоотой хянадаг байх;

3.2. Тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан аж ахуйн нэгжээс төрийн байгууллагын нэхэмжилж гаргуулсан нөхөн сэргээлтийн төлбөрийг орон нутагт зарцуулалт хийхээр төвлөрүүлэх;

3.3. Тусгай зөвшөөрөл олгохоос өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгүүлдэг байх, үнэлгээ хийлгэхэд орон нутгийн иргэд, ИН-ийн байгууллагын төлөөллийг оролцуулдаг байх;

4. УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ:

4.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий компаниуд 3 ба түүнээс дээш жилээр үйл ажиллагаа явуулаагүй бол эвдрэлтэй газраа нөхөн сэргээх шаардлага тавих, тусгай зөвшөөрөл цуцлах,

4.2. Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор авто зам барих ажилд маш олон тооны газар, талбай эвдрэл үүсэж байгаа тул нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах;

4.3. Сумдын ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагаа нээлттэй биш, олборлох салбарын мэдээллийг аймаг, сумдаар ангилж нэгтгэн харуулдаг, байнга шинэчлэл хийдэг, түүгээр дамжуулан харилцан мэдээлэл солилцдог, нийгмийн сүлжээний хуудас хэлбэрээр хийх;

4.4. Тухайн орон нутгийн орон зайн зураглал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, тэдгээрийн шилжилт, хөдөлгөөн, ашиг хүртэгч эзэд, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, байгаль орчны байдал, нөхөн сэргээлт, дэд зөвлөлийн үйл ажиллагаа гэх мэт бүх мэдээллийг хамруулсан цахим хуудастай болох;

4.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цаашдаа АМГТГ-аар олгуулдаг болгох;

4.5. Ашиглалтын зөвшөөрөлтэй боловч ашиглахгүй олон жил болсон газруудын зөвшөөрлийг цуцлах;

4.6. Уул уурхайн компанийн үйл ажиллагаа дууссаны дараа нөхөн сэргээлт хийсэн байдлыг ил тод гаргаж, мэдээлэх;

4.7. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн төлөө ажиллаж буй аж ахуйн нэгжүүдээ дэмжиж тэдний сайн жишгийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;

5. ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ:

7.1. АМТХ-нд бичил уурхайн асуудлыг хуулийн зохицуулалт хийх ажлын байрыг баталгаатай болгох мөн АМТХ-ийн 3.2-т бичил уурхай, 4.1.23. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох заалтуудыг хэвээр үлдээх;

6. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР:

- 6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох;
- 6.2. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн эзэмших эрхийн жилийг багасгах, бичил уурхайчдыг багасгах;
- 6.3. Тусгай зөвшөөрлийг ач холбогдлоор нь ангилах /төсөвт төвлөрүүлж буй орлого, ажлын байрны тоо гэх мэт/;
- 6.4. Бүх төрлийн тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн ИТХ-ын саналыг заавал авдаг байх;
- 6.5. Нөхөн сэргээлт хийгээгүй, стандартын бус хийсэн компаниудын тусгай зөвшөөрлийг сунгахгүй байх;
- 6.6. Цөөн тооны улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөх ордуудыг ашиглаж, жижиг уул уурхайнууд, олон тусгай зөвшөөрлийг цэгцлэх.

7. ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР:

- 6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн компанийн ТУЗ, ГЗ, ХЗ-ын мэдээллийг ил тод болгох;

8. АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:

- 8.1. Хариуцлагатай бичил уул уурхай эрхлэгчдийг тухайн орон нутгийн Засаг даргын тамгын газар бодлогын хүрээнд дэмжих;
- 8.2. Уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа хууль тогтоомжийн дагуу, түүний дотор хамтын ажиллагааны гэрээний дагуу багагүй хэмжээний татвар төлж, төлбөр хийж, мөн хандив тусламж өргөсөөр олон жил болж байгаа ба цаашид ч энэ хэмжээ нэмэгдэхээр байгаа юм. Гэтэл эргээд харахад уул уурхайн компани ба орон нутгийн иргэд, малчдын хоорондын зөрчил тэмцэл тасрахгүй байгаа ба тухайн сум, орны хөгжлийн тулгамдсан асуудлууд шийдэгдээгүй хэвээр байна. Орон нутагт төлж буй татвар, төлбөр, хандив тусламжийн зарцуулалт хангалтгүй байна гэсэн үг тул сайжруулах;
- 8.3. Компаниудын ус ашиглах дүгнэлт, ус ашиглах гэрээ, газар ашиглах гэрээ зэргийг ил тод болгох;
- 8.4. Уул уурхайн үйл ажиллагаанд хариуцлагагүй хандаж салбарын нэр хүндийг унагааж буй аж ахуйн нэгжүүдийг олон нийтэд зарлаж хуулийн дагуу авсан арга хэмжээг мэдээлэлдэг байх;

9. АЖ АХУЙН НЭГЖҮҮД:

9.1. Аж ахуйн нэгжүүдийн ус ашиглах дүгнэлт, ус ашиглах гэрээ, газар ашиглах гэрээ зэргийг орон нутагтай хамтран ил тод болгох;

10. ОҮИТБС-ын АЖЛЫН АЛБАНД:

10.1. АМТХ-ийн шинэчилсэн найруулга УИХ-д намрын чуулганаар батлагдсаны дараа ОҮИТБС болон МУУҮА-тай хамтран “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн гарын авлага”-ыг хэвлэн гаргаж олон нийтийн хүртээл болгох. Үүнд:

- ✓ Хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг эрх, үүргийг тусгах
- ✓ Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэг
- ✓ Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хэрхэн илгээх, баталгаажуулах талаар дэлгэрэнгүй тайлбар өгөх
- ✓ БОМТ-ыг хэрхэн батлуулах юу юу тусгах,
- ✓ Орон нутагтай хэрхэн хамтран ажиллах ямар бичиг баримт батлуулах,
- ✓ Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэг
- ✓ Уулын ажлын тайлан төлөвлөгөөг хэрхэн илгээх талаар заавар
- ✓ Тусгай зөвшөөрөл шилжүүлэх, барьцаалах, хэсэгчлэн болон бүрэн буцаан өгөх, хугацааг сунгах гэх мэт хөдөлгөөнтэй холбоотой бүх мэдээллээр хангах;

10.2. ОҮИТБС-ийн тайланг Сангийн яамны сайт, и-баланс, татварын ерөнхий газрын сайт, е-баримт, шилэн данс, e.tax.mta.mn зэрэг байгууллагуудын мэдээллийн сайттай холбож тайлан өгөхөд хөндлөнгийн мэдээлэл байдлаар ашиглах, баримт бичгийн үнэн зөв гэдгийг нотлох.

Хүрэлцэн ирсэн бүх оролцогч нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Чуулга уулзалтын оролцогчид:

- Эдийн засаг, хөгжлийн яам
- Байгаль, орчин аялал жуулчлалын яам
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам
- Ашигт малтмал, газрын тосны газар
- Авлигатай тэмцэх газар
- Экологийн цагдаагийн алба
- Дархан-Уул аймгийн ЗДТГ
- Сэлэнгэ аймгийн ЗДТГ
- Говьсүмбэр аймгийн ЗДТГ
- ОУИТБС-ын ажлын алба
- Төлсөн авснаа нийтэл эвсэл
- Монголын байгаль орчин, иргэний зөвлөл
- Нүүрс ассоциаци
- Цэнгэг Ерөө төрийн бус байгууллага
- Хотол чойр төрийн бус байгууллага
- Нөхөрсөг бичил уурхайчид төрийн бус байгууллага
- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
- Бороо гоулд ХХК
- Монполимент групп
- Болд төмөр Ерөө гол ХХК
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК

